


БИД ӨВӨРХАНГАЙЧУУД



И

Оюунсайханы

АЛТАНГЭРЭЛ

Тайлан сэтгүүл



МЭНДЧИЛГЭЭ

Өврийн сайхан хангай нутгийнхандаа өвлийн тэргүүн сарын мэндийг өргөн дэвшүүлье. Та бүхэн маань сайхан өвөлжиж байна уу.

Миний бие 2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшиж, 18 мянга орчим иргэнийхээ итгэлийг хүлээн, саналыг авсан нь нутаг ус, зон олныхоо төлөө ажиллах их урам, илүү хариуцлагын мөч байсан. Тиймээс төрөлх нутгийнхаа төлөөх үйл хөргээ улам өргөжүүлэх болно гэдгээ тухайн үед албан ёсоор олон нийтэд мэдэгдэж байсан.

Бусдын итгэл сэтгэлээс үүдсэн үүрэг хариуцлага үнэхээр хүчтэй байдаг юм байна гэдгийг өнгөрсөн хугацаанд өөрөө ч төсөөлснөөс илүү олон чиглэлд ажилласнаа эргэн хараад дүгнэж сууна. "Хийх хүнд арга олддог, хийхгүй хүнд шалтаг олддог" гэдэгчлэн асуудлыг жижиг том гэлтгүй тухай бүрт шийдэхийн төлөө ажилласан маань урт хугацаандаа олон эерэг үр дүнг авчирдаг юм байна. Тиймээс өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хийсэн ажлынхаа тайланг Та бүхэнд энэхүү сэтгүүлээр дамжуулан хүргэж байна.

Өвөрхангай нутагт хаягтай ажил бүхэн өвөрхангайчууд Та бүхэнтэй холбоотой үүх түүх юм. Тиймээс энэхүү сэтгүүлээ "Бид өвөрхангайчууд" гэж нэрлээд "Й" хэмээн тодотгож нутгийн зон олон та бүхэнд зориулан хүргэж байна. Өвөрхангайчууд бидний регистрийн дугаар дээрээ "овоглодог" Й үсэг бол Халхын анхдугаар богд Занабазарын зохиосон соёмбо үсгийн тигтэй хэлбэр ойр, улс даяар биднийг тодотгодог сэтгэлд бас ойр үсэг билээ.

Ийнхүү өвөрхангайчуудыг төлөөлөх "Й" үсгээр тодотгосон Оюунсайханы Алтангэрэл миний өнгөрсөн хугацаанд хийсэн ажлын тайлан сэтгүүлийг таалан соёрхоно уу.

Оюунсайханы

АЛТАНГЭРЭЛ

“О.Алтангэрэл: ОЛОН ТАЛТ ЧАДВАР БОЛ ӨВӨРХАНГАЙНХНЫ ОНЦЛОГ”



Сэтгүүлч: Д.Пүрэвсүрэн

2020 оны сонгуулийн багт нь орж явсны хувьд түүнийг өнгөрсөн хугацаанд Өвөрхангайн хэдэн сумын дунд жим гарал явж, завсаргүй ажилласныг нь мэдэх юм. Тэгээд ч дарга, сайд шиг иргэдтэй индэр дээрээс биш ахуй дунд нь уулзаж, ярилцдаг учраас асуудлаа мэднэ, тэр дагуу ажил хэргээ явуулна, тэр нь хүндээ шууд хүрнэ гэсэн зарчмитай ажиллаж иржээ. Энэ талаар түүнтэй товч ярилцлаа.

2020 оны сонгуулийн дүн зарлагдах тэр мөчид ялсан тал ялалтандaa ханасан бол таны хувьд илүү хариуцлагатай ажиллах дахин сэргэлт авсан мэт харагдсан. Тэр ч утгаараа өнгөрсөн 4 жил олон салбарт хүрч ажиллажээ. Эндээс хамгийн онцлог ажлаасаа нэрлээч гэвэл алийг нь дурдах вэ?

Би 2020 оны сонгуулийн маргааш мэдэгдэл хийж, нутаг орныхоо төлөө илүү олон зүйлийг хийх эхлэл боллоо гэж хэлж байсан. Тэр дагуу тухайн жилийн намраас боловсролын чиглэлээр ажлууд хийгээд эхэлсэн. Тухайн үед ковидын хөл хороо чангарч, хичээл завсарлаж байсантай холбоотойгоор Өвөрхангай аймгийн сурагчдын дунд онлайн сургалтууд явуулж, мөн дараа жилийн хавар нь онлайн давтлагын хичээл зохион байгуулсан. Цар тахалтай холбоотойгоор хүмүүнлэгийн чиглэлээр ажлууд нэлээд хийсэн. Ер нь өнгөрсөн хугацаанд нутаг орон руугаа чиглэсэн ажил

тогтмол хийж байсан учраас тэрийг нь гэж онцлоход бэрх. Тэр дундаасаа Өвөрхангайн ирээдүй болсон хүүхдүүдүүд рүү чиглэсэн ажлуудаа хамгийн түрүүнд эрэмбэлнэ.

УИХ-ын гишүүний хувиар ажиллах, хувь улстөрчийн үүднээс ажиллах хоёр мэдээж их ялгаа бий байх?

Олон ялгаа бий л дээ. УИХ-ын гишүүдийн хувьд тойрогоо зарцуулах олон зуун сая төгрөгийн төсөв байдаг. Бусад хангамж гэх мэт олон ялгаа гарна. Өнгөрсөн хугацаанд хийсэн ажлуудаа хэн нэгний хандив, тусlamжаар биш өөрийн хүчээр хийж ирснээ бардмаар хэлнэ. Нэг л хэцүү зүйл байдаг. Жишээ нь, би аль нэг чиглэлээр юм хийе гэхээр орон нутагт улстөржилт маш том саад болж байсан. Жишээ нь эрүүл мэндийн үзлэг үйлчилгээг орон нутагт явуулахад үзлэгт оролцсон эмч нарыг маань цаанаас нь дарамталдаг. УИХ-ын гишүүн орон нутагт очиход төрийн

алба тэр чигээрээ зүтгэдэг бол биднийг ажил зохион байгуулахад садаа болох зүйл их байдаг. Гэхдээ орон нутгийнхан бидний зохион байгуулж байгаа арга хэмжээнд хүчээр биш хүслээрээ оролцдог. Багш нар, эмч нар, малчид, ахмадууд гэх мэт Өвөрхангай аймгийг нуруун дээрээ авч яваа бүх хүн зохион байгуулсан үйл ажиллагаа болгоныг дэмжиж байсан. Тэр байтугай, хүүхэд багачууд хүртэл аливаа сурагчдад зориулсан арга хэмжээ зохион байгуулахад идэвхтэй оролцож байсан. Тиймээс төрийн мөнгөөр хийж байгаа ажлын дэргэд олон түмнийхээ хүчээр хийж байгаа миний ажил санхүүгийн хэмжээгээрээ бага байж болох ч оролцсон оролцоо, хийсэн ажлаараа хамаагүй их. Олон хүний хүч, итгэл сэтгэлээр энэ ажлуудыг хийсэн.



Дөрвөн жилийн өмнө бодож төлөвлөсөн ажил хэр үр дүнд хүрсэн гэж харж байна вэ?

Өнгөрсөн хугацаанд надад итгэж, санал өгсөн хүмүүсийн ачийг хариулж, нутаг орныхоо төлөө ажиллана гэж бодсоноосоо ихийг хийж, их ч явсан байна лээ. Нэг суманд гэхэд би хамгийн багадаа 10 орчим удаа очсон байна. Заримд нь түүнээс ч олон удаа очсон байна. Иргэдийн төлөөлөлтэй уулзаж, ялангуяа хөдөө орон нутагт тулгарч байгаа асуудал юу байна вэ гэдгийг илүү сайн ойлгосон. Тэр үед ингэж их явж, ийм олон ажил амжуулна гэж бодоогүй, өөрийнхөө хүлээлтээс илүү хийсэн гэж бодож байна.

Орон нутагт тулгардаг нийтлэг асуудал нь юу байна вэ?

Асуудал олон байна. Ахмадуудын хувьд тэтгэвэр тэтгэмжийн асуудал байхад хүүхэд багачуудын хувьд чанартай боловсролын асуудал байна. Хaa очиж манай аймаг маш сайн бэлтгэгдсэн боловсон хүчинтэй, багш нар сайтай. Түүндээ л боловсролын систем нь яваад байдаг болохоос биш эргээд багш нарынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөгжилд нь хөрөнгө оруулах тал дээр учир дутагдалтай байгаа. Малчдын хувьд олон жилийн турш шийдэгдэхгүй байгаа асуудал бол малын гаралтай түүхий эдийн үнэ зах зээлийн үнэлгээндээ

нийцэхгүй явсаар ирсэн.

Өвөрхангай аймаг нийслэлтэй харьцангуй ойрхон. Арвайхээр, Хархорин хот бол Дархан, Эрдэнэтийн дайтай хөгжих боломжтой, энэ нэхцэл хангагдахгүй байна. Гэрэлтүүлэг, дэд бүтэц гэх мэт сүм болгонд өөрийн асуудал байна. Нийтлэгээрээ аймгийн хэмжээнд хамгийн анхаарах асуудал бол иргэдийн амьдралын чанар байна. Төрийн үйлчилгээ, баялгийн хуваарилалт иргэддээ тэгш очиж байна уу, үгүй юу. Төрийн дээд төвшинд нүүрлэсэн энэ их хулгай орон нутгийн иргэдэд яж тусаж байна вэ. Манай улс сүүлийн 3 жил түүхэнд байхгүй их нүүрс экспортолж байна. Энэ яагаад манай



Монголын аял түмэн буд
-улсынхаа туслгаар тогтнол, булаг зорч байдлыг баталтан бэжүүл
й эрх, эрх чөлөө, шударга бий болгоход нийтээ зөв ногдлийг эрхэмлэн д
-тарт ёс түүх, сийн түүхийг хөгжүүлж наандигчны авлож,
-сүн төрөлжтөний сийн түүхийг эволюцийг хүндэтгэн үзэж,
ирондоо дүүрүүтэй, иргэдийн түүхийгээ огтуулсан хөгжүүл
ж зорилго болгоно. Урианжуулж Монгол Улсын Үндсэн хуулийг даваа
зардлаад, энэхүү хувьд төслийн төхөөрөмжийн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн төслийн төхөөрөмжийн байна.

аймгийнханд ирж наалдахгүй
байна. 2023 оны хайгуулын үр
дүнгээр Баянтээгийн уурхай
ижил төрлийн ордуудаасаа
хамгийн гүний нүүрстэй уурхай
нь тогтоогдсон. БНХАУ-ын
компанитай гэрээ байгуулаад
өдөр шөнөгүй нүүрс зөөж
байна. Энэ яагаад ард иргэдийн
амьдралд аятайхан сайхнаар
нөлөөлөхгүй байна. Энэ мэт орон
нутагт асуудал дэндүү ужгирсан,

удсан байна. Шийдэл тал дээр
юм хийхгүй байна.

Таны хувь хүний хувьд хэр өөрчлөлт гарав?

Мэргэжлийн хувьд эрдэм
шинжилгээний хоёр ч чиглэлээр
докторын ажил бичээд дуусаж
байна. Авиалгын чиглэлээр 5
том цуврал судалгааг хийж
дуусгалаа. Үүнийгээ хэвлүүлэх

“

Хүмүүс асуудаг л даа.

**Чи ямар заваараа
судалгаа хийгээд,
кино бичээд, улс төр
хийгээд, талбай дээр
очиж жагсаад яваа юм
бэ гэж. Хүн өөрийн
чадах зүйлээ боломжит
цаг хугацаандаа
хийж л байх ёстой.**

**Карьерийнхаа хувьд
би ид үедээ явж
байна гэж боддог.**

**Энэ хавар эрдмийн
зэргээ хамгаална.
Судалгааны ажлаа ч
цаашид үргэлжлүүлнэ.
Улс төрийн тэмцлээ ч
хийнэ, Уран бүтээлийн
ажлаа ч орхихгүй ээ.**

”

гэж байна. Төлбөрийн чадваргүй
нэлээд олон хүнд хууль зүйн
туслалцаа үзүүллээ. Уран
бүтээлчийн хувьд Монголын
кинонуудаас хамгийн анх
таван тивийн кино наадмуудад
шалгарч, 13 кино наадмаас
шагнал авсан, Европын А
зэрэглэлийн 2 кино наадам,
Азиин олон кино наадамд
тэргүүн байр эзэлсэн “Трио”
гэдэг уран сайхны киноны
зохиолч, продьюсерээр ажиллаж,

ОНЦЛОХ МЭДЭЭ

**“БАЯНТЭЭГ”
ХК-ИЙН ХУВИЙГ
ӨВӨРХАНГАЙЧУУДАД
ЭЗЭМШҮҮЛЭХ
САНААЧИЛГЫГ
О.АЛТАНГЭРЭЛ
ГАРГАВ**

Өвөрхангай аймгийн “Баянтээг ХК”-ны хувьцааны тодорхой хувийг Өвөрхангай аймгийн иргэдэд эзэмшүүлэх санаачилгыг анх АН-ын дэд дарга О.Алтангэрэл гаргасан билээ. Энэ тухай шаардлага болон тогтоолын төслийн хамт 2019 оноос эхлэн удаа дараа уйгагүй хүргүүлснээр нааштай хариу гарахаар болоод байгаа юм. Өвөрхангай аймгийн иргэдэд тус уурхайн 19 хувийг эзэмшүүлэх талаар ИТХ-аар хэлэлцэгдэж буй юм. Ийнхүү байгалийнхаа баялгийг өвөрхангайчууд тэгш хүртэх энэхүү санаачилга удахгүй биелэлээ олно биз ээ.



багын найз Д.Баттөмөрийн хамт тив дэлхийд хүрсэн амжилт гаргалаа. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Алтангэрэл” сангийн шугамаар үйл ажиллагаагаа тогтвортой явуулсаар ирсэн.

Хуульч, судлаач, кино зохиолч гээд энэ олон өөр салбарт яаж зэрэгцэн ажиллаад байна вэ?

Хүмүүс асуудаг л даа. Чи ямар заваараа судалгаа хийгээд, кино бичээд, улс төр хийгээд, талбай дээр очиж жагсаад яваа юм бэ гэж. Хүн өөрийн чадах зүйлээ боломжит цаг хугацаандaa хийж л байх ёстой. Карьерийнхаа хувьд би ид үедээ явж байна гэж боддог. Энэ хавар эрдмийн зэргээ хамгаална. Судалгааны ажлаа ч цаашид үргэлжлүүлнэ. Улс төрийн тэмцлээ ч хийнэ,

Уран бүтээлийн ажлаа ч орхихгүй ээ. Өвөрхангайгаас төрөн гарсан оюуны чадамжтай хүмүүст олон талт чанар түгээмэл байдаг. Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Г.Батхүү гэж сайхан хүн байлаа. Түүний “Толин хул” дууг монгол хүн бүр наадам болохоор дуулдаг, наадмын сүлд дуу болсон. МАН-ын төрийн түшээ Д.Лүндээжанцан гуайн бичсэн “Арвайхээрийн хавар” дууг бүгд мэддэг байх жишээтэй. Ер нь төв халхын голомт Өндөр гэгээн Занабазарын нутгийнханд заясан оюуны үзүүр юм болов уу. Үүнийгээ хөгжүүлж, түгээж явах нь энэ нутгаас төрж гарсан хүмүүсийн үүрэг юм болов уу гэж боддог.

О.Алтангэрэлийн өвөө Д.Жамбаа Өвөрхангай аймгийн дээд боловсролтой, анхны шүүгчдийн нэг. “Би өвөөгөө хараагүй ч ул мөр нь үргэлж хамт байсан. Тухайн үе зах зээлийн шилжилтийн үе байлаа. Цахилгаан их тасарна. Хоолтой хоолгүй янз бүрийн үе байна. Тэгэхэд “Өвөө чинь ийм хүн байсан шүү, миний хүү” гээд буурай ээж ярьж өгнө. Мөн түүний харьян дор, хамт ажиллаж байсан хүмүүс болох хуульзүйн шинжлэх ухааны доктор Мөнхжаргал, доктор Баасан багш гээд хуульзүйн салбарын ноён оргилууд өвөө чинь муундаг хүн байсан шүү гэж хэлэх хүнтэй олон таарсан” гэж тэрээр ярьсан. Нэг ёсондоо хуульч мэргэжил түүнд хүүхэд насны сониуч зангаар мэргэжил бүхэнд дурладаг үеэс нь л өөр сонголтгүйгээр үүрэг даалгавар

“Дэнс” хөрөг нийтлэлээс



“Хөрөг” нийтлэлийг бүтнээр нь уншихыг хүсвэл дээрх QR кодыг уншуулна уу.

АЛТАНГЭРЭЛ САНГААС ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

Нутаг орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготой, ирээдүйг дэмжигч "Алтангэрэл сан"-г **2019** онд байгуулсан бөгөөд өнгөрсөн хугацаанд үйл ажиллагааны хүрээ өргөжин тэлсээр байна. "Өлзий-Орших" ахмадын төвийг 2013 онд Уянга суманд байгуулж, үйл ажиллагааг нь өргөжүүлэн Арвайхээр болон бусад 3 суманд ажиллуулж байсан цагаас хойш тооцвол О.Алтангэрэлийн Өвөрхангай нутагтаа зориулж ажил үйлс хийж эхэлсний 10 жилийн ой энэ онд тохиож байна.



"Шинэ Өвөрхангай" төслийг 2018 оноос Асашорьюу Д.Дагвадоржтой хамтран хэрэгжүүлж,

100 гаруй хүнийг ЯПОН улсад ажлын гэрээгээр ажиллуулав.



2008 оноос эхлэн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж эхэлсэн бөгөөд **2016** онд "Иргэний хамгаалалт" хууль зүйн туслалцааны төвөөр дамжуулан Монгол Улсын хэмжээнд **6000** гаруй иргэнд **хууль зүйн туслалцаа** үнэ төлбөргүй үзүүлсэн.



"Гэрэлт ирээдүй" сурагчдад боловсрол олгох хөтөлбөрийг 2019 оноос

хэрэгжүүлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд **120** гаруй сурагч хамрагдав.



2020 оноос "**БОЛОВСРОЛ**" хөтөлбөрийг хэрэгжүүлэн Өвөрхангай аймгийн нийт сурагчдад зориулан математик, нийгэм, химийн хичээлийг онлайнаар амжилттай зохион байгуулж,

1000 гаруй хүүхэд хамрагдав.



Нийгмийн хариуцлагын хүрээнд

12 айлыг орон гэртэй болгов



Өвөрхангай аймгийн өвөлжилт хүнд сумдад

120 гаруй тонн хивэг үйлдвэрийн үнээр тараасан.

9

сумын сургуульд хичээлийн тэнхим шинээр тохижуулах болон гадаах талбайг шинэчлэн засварлаж, дотуур байранд амрах, өөрийгөө хөгжүүлэх өрөөг бий болгов.



"Тэтгэлэгт оюутан" хөтөлбөрийн хүрээнд "**АЛТАНГЭРЭЛ САН**"-гийн нэрэмжит оюутны сургалтын төлбөрийн **Тэтгэлгийг 15 сурагчид** олгов.



Нутгийн спортын салбарынхнаа үргэлж дэмждэг бөгөөд **21** баг болон

25

хувь тамирчдад санхүүгийн тусламж үзүүлэв

19

Урлаг соёлоор дамжуулан нийтийн боловсрол олгох ажлыг **Өвөрхангай аймгийн бүх сумдад** зохион байгуулав.



Боловсрол

Энэ салбарт хийсэн онцлох ажлуудаас дурдвал ерөнхий боловсролын 5 сургуульд түүхийн тэнхимийг тохижуулсан, багш наарт амарч тухлах жишиг өрөөг бий болгосон, дотуур байрны сурагчдын өөрийгөө хөгжүүлэх өрөөг тохижуулсан. Түүнчлэн ITU мэдээлэл технологийн, мэргэжлийн чиг баримжаагаа олох сургалт, ковидийн үед хичээл, сургалтаас завсардахгүй байхад чиглэсэн онлайн хичээл гэх мэт хүнд нь оруулсан хөрөнгө оруулалтуудыг ч нэрлэж болно.

41

36

38

25

23

13

“Алтангэрэл сан”-гаас өнгөрсөн 4 жилд хэрэгжүүлсэн ажлыг салбараар нь ангилбал доорх тоон үзүүлэлт гарч байна. Жишээлбэл боловсролын салбар 41, хууль эрхзүйн салбарт 36 гэх мэт тухайн салбарт хамаарах төрөл бүрийн ажлыг нэгтгэн дүгнэх байдлаар гаргасан болно.



Хууль, эрхзүй

Олтангэрэл хуульч мэргэжлийнхээ хүрээнд нийгэмд хандсан олон арга хэмжээ санаачилж, хамтран оролцсон ажлууд цөөнгүй. Тэр дундаа УИХ дахь АН-ын гишүүдтэй хамтран хуулийн төсөл боловсруулсан, төрөлх сумандаа анх удаа ус цэвэршүүлдэг уурхайтай болох төслийн зөвлөхөөр ажилласан гээд дурдвал олон. Мөн Өвөрхангай нутгийн ард иргэдэд хууль зүйн үнэгүй тусламж үзүүлэх ажлыг тогтмол хийсээр байна.



Хүмүүнлэг

Түүний хүмүүнлэг чиглэлээр хийсэн ажлын учиг “Өлзий орших” ахмадын төвөөс эхтэй. Өдгөө тэрээр зөвхөн ахмадууд гэлтгүй, нутаг орны иргэдээс хүссэн хандив тусламжийг олон чиглэлийн олон хүнд өгсөөр ирснийг өвөрхангайхан андахгүй.



Спорт

Нутаг орноосоо төрөн гарсан, ирээдүйтэй залуусаа спортын амжилт гаргахад тусалж дэмжиж, үргэлж эргэх холбоотой байдаг хүмүүсийн нэг бол яах аргагүй О.Алтангэрэл. Тэрээр өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд залуу, ахмад бүх үеийг хамарсан олон төрлийн тэмцээн, наадам зохион байгуулсан.

Эрүүл мэнд

Цар тахлын үед эрүүл мэндийн салбарынхантай ойр ажиллаж, бололцоот тусламжийг үзүүлснээс гадна орон нутгийн иргэдийг үнэ төлбөргүй үзлэгт хамруулах ажлыг нэлээд өргөн хүрээнд зохион байгуулсныг энд онцолж болно.

Урлаг

Олтангэрэл өөрөө уран бүтээл хүний хувьд энэ салбартай ойр. Тиймээс өнгөрсөн хугацаанд орон нутагт урлаг соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг Өвөрхангай аймгийн бүхий л сүмдад явуулснаараа онцлогтой.

БОЛОВСРОЛ



“

Ээж маань багш, эмээ маань олон жил цэцэрлэгийн эрхлэгч хийсэн хүн байсан гээд боловсролын салбарт ойр байх шалтгаан надад олон. Боловсролтой иргэнтэй байж хөгжлийн зөв урсгалтай улсын тухай яригдах учраас энэ салбарыг онцгой анхаарах ёстой гэж боддог. Тэр тусмаа суурь боловсролын чанар их чухал. Сайн сургууль гэдэг бол олон метр квадрат талбайтай сургуулийг биш, сайн багш нартай сургуулийг хэлдэг. Тиймээс миний хувьд эд зүйлд биш хүнд нь хөрөнгө оруулахыг зарчмаа болгодог. Мэдээж сурх орчин чухал. Тэр утгаараа 12 сумын хичээлийн танхимыг бүрдүүлж, хүүхдийн хөгжих боломжийг дэмжсэн амрах өрөө, гадаах талбайг тохижуулах ажил хийллээ.

”

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ОЛОН ТӨРЛИЙН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭВ



“Алтангэрэл сан”-гаас явуулж буй ажлуудын нэг тэргүүлэх чиглэл нь боловсролын салбар руу хандсан байдаг. Тухайлбал, өнтөрсөн хугацаанд Өвөрхангай аймгийн нийт сурагчдад зориулсан “Боловсрол”, ахлах ангийн сурагчдад зориулсан “Гэрэлт ирээдүй”, “Тэтгэлэгт оюутан” зэрэг хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн нь ЕБС-ийн сурагчдын оюуны хөгжлийг дэмжсэн том хөрөнгө оруулалт байлаа. Зарим ажлаас нь дурдвал, “Боловсрол” хөтөлбөрийн

хүрээнд цар тахлын хөл хориотой үед Өвөрхангай аймгийн нийт сурагчдад зориулан математик, нийгэм, химийн хичээлийг онлайнаар амжилттай зохион байгуулсан. Мөн “Гэрэлт ирээдүй” хөтөлбөрийн шугамаар ITU мэдээллийн технологийн салбарыг ахлах ангийн сурагчдад таниулах, цаашлаад мэргэжлээ сонгоход туслах зорилготой цуврал лекц, хөгжөөнт сургалтыг Өвөрхангай аймгийн Арвайхээр болон Хархорин хотод амжилттай зохион байгуулсан. Өвөрхангай аймгийн хэмжээнд сурлагын өндөр амжилт үзүүлсэн сурагчдад зориулсан “Тэтгэлэгт оюутан” хөтөлбөрийн хүрээнд их сургуулийн сургалтын төлбөрийн тэтгэлгийг олгодог бөгөөд энэ оны хувьд 3 сурагчид олгоод байна. Энэ мэт өнгөрсөн хугацаанд явуулсан арга хэмжээг дурдвал олон бөгөөд цаашдаа ч дээрх хөтөлбөрүүдийг урт хугацаандаа хэрэгжүүлсээр байх юм.



Өвөрхангай аймгийн ТМС-ийн байрны гадаах талбайн хүүхдийн тоглоомын талбайг засан сайжруулж шинэ тоглоомоор баяжуулсан.



УРЛАГИЙН БОЛОВСРОЛ БОЛ ХҮН ЧАНАРЫН БОЛОВСРОЛЫН НЭГ СУУРЬ

Манай улсын ерөнхий боловсролын системд орхигдоод байгаа нэг зүйл бол урлагийн чиглэлийн хичээлүүд. Хичээлийн хөтөлбөрт заасан байдаг ч жишээ нь дуу хөгжмийн хичээл мэргэжлийн багш, хичээлийн хэрэглэгдэхүүний дутмаг байдал зэргээс болж орохоосоо орохгүй нь их. Хөгжилтэй орнуудын хувьд урлагийн боловсрол нь хүн чанарын боловсролын суурь хичээл гэж үздэг учраас энэ төрлийн хичээлд их ач холбогдол өгдөг.

"Алтангэрэл сан"-гаас хүүхдийн урлагийн боловсролд анхаарсан цөөнгүй ажил зохион байгуулдгийн нэг жишээ нь Өвөрхангай аймгийн ЕБС-ийн сурагчдын дунд зарласан "Миний сайхан нутаг" гар зургийн уралдаан. 92 уран бүтээл ирүүлснээс нас настын ангилалд шилдгээр шалгарсан 32 сурагчийн бүтээлээс хүүхдийн сэтгэлгээний цар ямар өргөн болохыг харж болно.

Мөн тус сангаас Өвөрхангай аймгийн нийт сумдын хүүхдүүдийн дунд Багш нарын баярт зориулсан "Багшаа баярлалаа" зохион бичлэг "Миний мэдэх багш" эсээ бичлэгийн уралдаан зарлаж нийт 150 гаруй сурагчид оролцсон байна. Түүнчлэн Өвөрхангай аймгийн нийт ахлах ангийн сурагчдын дунд фото зургийн уралдаан зарласан гэх зэргээр хүүхдийн урлагийн боловсролыг дэмжсэн, далд авьяасыг нь нээсэн уралдаан, тэмцээн олныг зохион байгуулдаг.

✓ Гэрэлт ирээдүй" ахлах ангийн сурагчдад боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд 50 гаруй сурагчид гарын бэлэг өгөв.

✓ Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Бат-Өлзий, Уянга, Хархорин сумын сургуулийн химиийн хичээлийн танхимд сургалтын хэрэглэгдэхүүн бэлэглэв.

✓ Зүүнбаян-Улаан сумын төрийн албан хаагчдын дунд хүний хөгжлийн сургалтыг Ардчилал академитай хамтран зохион байгуулсан.

✓ Өвөрхангай аймгийн ЕБС-ийн 90 гаруй сурагчид хичээлийн хэрэгсэл бэлэглэсэн.

✓ Өвөрхангай аймгийн Хархорин сумын багш нарын төлөөлөл болох 18 багшийг хүлээн авч боловсролын салбарын тулгамдаад байгаа асуудал, хөдөө орон нутгийн төрийн албан хаагчдын ажлын нөхцөл байдалтай танилцах арга хэмжээ зохион байгуулав.

Өвөрхангай аймгийн Хужирт сумын соёлын төвийн бүжгийн сургалтад хамрагддаг

✓ хүүхдүүдэд бүжгийн тэмцээнд оролцоход нь туслалцаа үзүүлсэн бөгөөд багууд амжилттай оролцож шагналт байрт шалгарсан.

✓ Өвөрхангай аймгийн нийт сумдын хүүхдүүдийн дунд Багш нарын баярт зориулсан "Багшаа баярлалаа" зохион бичлэг "Миний мэдэх багш" эсээ бичлэгийн уралдаан зарлаж нийт 150 гаруй сурагчид оролцсон.

✓ Жаргалант багийн цэцэрлэгийн хүүхдүүдэд тоглоом бэлэглэв

✓ Арвайхээр хотын 1 дүгээр сургуульдаа анги тохижуулж хүлээлгэн өгч, зөөврийн компьютер бэлэглэлээ

✓ Өвөрхангай аймгийн 2-р сургуулийн "Соёмын залуус" клубын залуу багш нарыг хүлээн авч, Сант сургуультай туршлага солилцов.

✓ Өвөрхангай аймгийн сэтгүүлчдэд фм радио, тоног төхөөрөмжийн хамт бэлэглэлээ



Залуу уяачдыг дэмжих зорилгоор Улсын манлай уяач Г.Батчулууны "Хурдан морины уяа, сойлго" лекцийг Өвөрхангай аймгийн бүх сумдаар зохион байгуулав. Энэ төрлийн арга хэмжээ зохион байгуулсан хоёрдахь аймаг болов.



Хархорин сумын багш нарын амралтын өрөөг тохижуулж өгөв



Арвайхээрийн 1-р сургуулийн ангийг тохижуулав.



Баян-Өндөр суманд Түүхийн танхимийг тохижуулж засвар хийж өгсөн.



Уянга сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль Оюун багшийн хүсэлтийг үндэслэн "Түүхийн танхим"-ийг бүрэн засвар хийж ухаалаг танхим болгох зорилгоор хүүхдэд ээлтэй орчин үеийн бүрдүүлж дэвшилтэй технологи бүхий тохижилттой болгон хүлээлгэн өгсөн.



Зүүнбаян-Улаан сумын ЕБС-ийн дотуур байрны хүүхдүүдийг амрах, өөрийгөө хөгжүүлэх өрөөг иж бүрэн тохижуулж өгсөн.



Өвөрхангай аймгийн Сант суманд түүх нийгмийн ухааны танхимд засвар хийж тохижуулж өгсөн.



Хужирт сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын амралтын өрөөг бүрэн засварлаж, амрах ая тухтай орчинг бүрдүүлэв.



Арвайхээрийн 5-р сургуулийн хүүхдүүдэд цахим номын сан тохижуулж өгөв.

ХУУЛЬ, ЭРХЗҮЙ



“

Хуульч мэргэжлийнхээ хүрээнд “Иргэний хамгаалал” ТББ-аараа дамжуулан өмгөөллийн ажлаа тасралтгүй явуулахын зэрэгцээ УИХ-д сонгогдсон намын гишүүдтэй хамтран цөөнгүй хуулийн төсөл дээр ажиллалаа. Ер нь УИХ дээр яригдаж байгаа бодлогын бичиг баримтууд дээр хуульчийн зүгээс аль болох идэвхтэй оролцохыг хичээдэг л дээ. Жишээ нь, Үндсэн хуулийн асуудлаар УИХ-ын гишүүн тус бүрт захидал илгээн саналаа уламжилж, улмаар санал маань олонхоор дэмжигдэж байсан. Түүнчлэн авилгын чиглэлээр хийсэн цуврал судалгаагаа энд дурдах нь зүйтэй байх. Өнгөрсөн хугацаанд хувь хуульч, улс төрчийн зүгээс нийгмийн асуудлуудад оролцож байсан гэхэд үр дүнгийн хувьд чамгүй амжилт гаргасан гэж үздэг.

”

УЯНГА СУМ БОХИРДОЛ УСАА ЦЭВЭРШҮҮЛДЭГ АНХНЫ УУРХАЙТАЙ БОЛОВ

Монгол Улсын Байгаль орчин аялал жуулчлалын яам, БНСУ-ын "Хүрээнд буй орчны аж үйлдвэр технологийн институт", "Ta ta" ХХК хамтран

Өвөрхангай аймгийн Уянга сум дахь "АУМ Алт" компанийн уурхайд уул уурхайн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийг суурилууллаа. Ингэснээр тус уурхай усаа өндөр технологиор хэрэглэсэн усаа цэвэршүүлдэг анхны уурхай болж байна. Тус төслийн санаачлагчаар Э.Ганбат, зөвлөхөөр О.Алтангэрэл ажилласан юм.



Бат-Өлзий сумын Мод бэлтгэж байгаа иргэдтэй газар дээр нь буюу гол болон хээр гарсан байрлалд нь очиж уулzan амьдрах орчин ямар нөхцөлд ажиллаж байгаа зэрэгтэй танилцан тулгаргаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх арга замын талаар ярилцсан.

СЕМДЕМ ТОВЧИМЭДЭ



- ✓ УИХ-ын гишүүн Б.Пүрэвдоржтой хамтран "Зөрчлийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ УИХ-ын гишүүн Н.Тувааны хамтаар "Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ УИХ-ын гишүүн Н.Ганибалын хамтаар "Хог хаягдлын тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг өргөн барьсан.
- ✓ УИХ-ын гишүүн С.Одонтуяатай хамтран "Төрийн албан хаагчийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн санал боловсруулсан.
- ✓ УИХ-ын гишүүн Адъяасүрэнгийн хамтаар "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр" санаачлан хэрэгжүүлсэн. Мөн "Гэрч, хохирогчийг хамгаалах тухай", "Гэр бүлийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөл боловсруулж ажилласан.
- ✓ Хархорин сумыг хот статустай болгох ажлын хүрээнд тус сумдын иргэдээс 1200 гаруй гарын үсэг цуглуулж, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын даргад хүргүүлсэн.
- ✓ Уянга, Баруунбаян-Улаан, Бүрд сумын намын гишүүд, иргэдтэй уулзаж намын өнөөгийн байдал болон төрөөс баримталж буй бодлого иргэдийн амьдралд нөлөөлсөн байдал зэргийг хэлэлцсэн уулзалт зохион байгуулсан.
- ✓ Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх саналаа УИХ-ын дарга гишүүдэд хүргэж, хэлэлцүүлгүүдэд оролцсон.

✓ Баян-Өндөр, Хужирт, Уянга, Баруунбаян-Улаан, Сант, Төгрөг сумын ИТХ-ын төлөөлөгчдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого болон сум орон нутагт дутагдалтай байгаа асуудлыг хэлэлцэн уулзалт зохион байгуулсан.

✓ Өвөрхангай аймгийн Уянга суманд Алтангадас одон Өвөрхангай аймгийн Ардчилсан намаас тодорхойлсноор шагнуулсан юм.

✓ Өвөрхангай аймгийн нийт иргэдэд хууль зүйн анхан шатны туслалцааг үнэ төлбөргүй хүргэх ажлыг тогтмол хийсээр байна.



Хульч О.Алтангэрэл өнгөрсөн жилүүдэд эрх баригчдын алдаатай бодлого, ард түмний эрх ашигт харшилсан, хууль бус шийдвэрүүдийн эсрэг тэмцлүүдэд оролцсоор ирсэн юм. Тухайлбал, 2021 онд УИХ-ын гишүүн С.Ганбаатар, Н.Алтанхуяг нарын толгойлсон улс төрийн тэмцэлд Сүхбаатарын талбайд суулт зарлан хамт оролцсон. Мөн нүүрсний хулгайн жагсаалд жагсагчдын хуулийн зөвлөхөөр ажилласнаас гадна Улсын дээд шүүхийн хууль бус үйл ажиллагааг эсэргүүцэн жагсаал хийж, шаардлагааг хүргүүлсэн гээд дурдвал тэрээр шударга тэмцэл бүхний дуу хоолой болсоор ирсэн билээ.



ЭРҮҮЛ МЭНД



“

Манайд өдгөө онцгой анхаарах ёстой байгаа нэг салбар бол эрүүл мэндийн салбар. Сайн эмнэлэг гэж сайхан барилгатай газрыг хэлэхгүй, мэргэшсэн, чадварлаг эмч нартай эмнэлгийг хэлнэ. Орон нутагт ажиллаж байгаа эмч нарынхаа нийгмийн асуудалд анхаарах, ажиллах нөхцөлийг сайжруулах цаг аль хэдийн болсон. Цар тахлын хүнд үед орон нутгийн эрүүл мэндийн төв болон онцгой байдлын албадад шаардлагатай зүйлээс тусалж хамтран ажилласан.

”

- ✓ “Өлзий орших” ахмадын төвийн ахмадуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулав.
- ✓ Цар тахлын үед Богд, Баян-Өндөр, Өлзийт, Бүрд сумын иргэдэд шаардлагатай эм бэлдмэл болон санхүүгийн дэмжлэгээр тусалсан.
- ✓ Цар тахлын үеэр Өвөрхангай аймгийн онцгой комисст Hyundai маркийн автобус бэлэглэв.
- ✓ Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Бат-Өлзий, Уянга, Хархорин сумын эмнэлэгт амьсгалын аппарат бэлэглэв.
- ✓ Богд, Баруунбаян-Улаан сумын онцгой комисс, эрүүл мэндийн төвд ковидоос сэргийлэх шаардлагатай эм бэлдмэл болон шатахууны дэмжлэг үзүүллээ.
- ✓ Бүрд, Өлзийт, Баян-Өндөр сумдад очиж ковидын нөхцөл байдалд дэмжлэг болох зарим зүйлсийг халдварт хамгааллын дэглэм сахин сумын төв оролгүйгээр хүлээлгэж өглөө.
- ✓ Олон Улсын сувилагч нарын баярыг тохиолдуулан Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нийт 260 гаруй сувилагчид хүндэтгэл үзүүлсэн.
- ✓ Хужирт, Хархорин, Өлзийт сумын иргэдэд эрүүл мэндийн үнэ төлбөргүй үзлэг явуулав.



ХҮМҮҮНЛЭГ



“

Надад хөшөө дурсгалд
өргөсөн хандив байхгүй.

Хүнийг чиглэсэн үйл
ажиллагаанд л хандив өгөх
дуртай. Эд цуглуулах хобби ер
байдаггүй. Хэдэн арван сая
төгрөгөөр үнэлэгддэг хөөрөг
хараад энэ нэлээд олон айлын
хүүхэд англи хэлний сургалтад
суух мөнгө байна даа гэж
бодож харамсдаг. Түүний
оронд хүн дэмжвэл үр дүн
нь хамгийн сайхнаар гардаг
байхгүй юу.

✓ Ахмадуудаа дэмжин ОХУ-ын
Улан-Үдэ хот руу явуулж,
Итгэлт хамбад мөргүүлсэн.

✓ Цар тахлын үед
Улаанбаатарт суралцаж буй
Өвөрхангай аймгийн харьяат
100 гаруй оюутанд хоол
хүнс болон мөнгөн тусламж
үзүүлэв.

✓ Байгалийн гамшигт өртсөн
Есөнзүйл, Арвайхээр,
Хархорин сумын үерт өртсөн
5 өрхөд өргөө цагаан гэр
бэлэглэв.

✓ Жил бүрийн Цагаан сарын
босгон дээр Өвөрхангай
аймгийн нийт ахмадуудаа
хүлээн авч хүндэтгэл
үзүүлдэг.

✓ Өвөрхангай аймгийн зарим
сумын цэцэрлэгийн бяцхан
сурагчдад шинэ жилийн
бэлэг гардууллаа.

✓ “1000 мод” төслийн хүрээнд
Өвөрхангайн Баруунбаян-
Улаан сумын захиргаанд
30,000 бортог хандивлалаа.

✓ Уянга сумын ИТХ-ын
төлөөлөгчид, албан
хаагчдыг Улаанбаатар хотод
сургалтанд хамрагдах үеэр
хүлээн авч хүндэтгэл үзүүлэн,
сумын захиргаанд өдөр
тутмын үйл ажиллагаанд
чухал хэрэгцээтэй зүйлсийг
хандивласан

✓ Бээлийн хүрээг засварлахад
хандив өргөсөн.

✓ Өвөрхангай аймгийн
Ид шидийн оронд мод
тарьж, цахим номын сан
байгуулахаар болсон.

✓ Хангайн 5 суманд
цэцэрлэгийн насны 2500
хүүхдэд гутал бэлэглэв.



“Алтангэрэл сан”-гийн урилгаар
Арвайхээр, Уянга, Хужирт, Бат-
Өлзий, Хархорин, Зүүнбаян-
Улаан суманд Энэтхэг улсын “
Сэра Жэй” хийдийн лам, гэвш
нар Хутагтын дөрвөн үнэн, Бодь
сэтгэлийн талаар бурхны ном
тайлбарлаж, Ногоон дарь эхийн
сахиусны хурал хурж, ажил үйлс,
эд баялаг, амь насны ном хурж
даллага авсан.



Спорт бол хүнд өв тэгш хүмүүжил олгодог, нийгмийн эрүүл мэндийг сий болгодог гэж үздэг. Тиймээс энэ салбарт боломжоороо дэмжлэг үзүүлэхийг хичээдэг. Манайхан дэмжихэд ч урамтай. Нэг хүүхэд дэмжихэд л медал аваад ирдэг. Би өөрөө үндэсний бөхөд дуртай. Нутгийн дүү нараа байнга дэмждэг. Өнгөрсөн жил “Өвөрхангайн бөх түрүүлвэл Д.Пүрэвдорж гуйн “Өвөрхангайн магтаал”-аа дуулах уу” гэж наадмын өмнөхөн пост оруулж байлаа. Тэрний доор Увс, Ховдын найзууд “Танайхаас хэн түрүүлэх юм бэ” гээд дооглож байсан. “Амны бэлгээс ашдын бэлгэ”-ээр Ц.Бямба-Отгон маань үзүүрлэлээ, улмаар арслан цолын болзлоо хангалаа.



СПОРТЫГ ДЭМЖИХ НЬ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ХӨРӨНГӨ ОРУУЛЖ БУЙ ХЭЛБЭР

“Алтангэрэл сан”-гаас үндэсний бөх төдийгүй багийн спортыг дэмжсээр ирсэн. Өнгөрсөн хугацаанд энэ чиглэлээр багагүй ажил хийснээс дурдвал Өвөрхангай аймгийн сур харвааны холбоонд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. Мөн Бат-Өлзий суманд 7 сумын бөхчүүд оролцсон Хангайн бүсийн бөхийн барилдааныг хамтран зохион байгуулсан. Гар бөмбөг, сагсан бөмбөг, дардс, шагайн харваа, нумт харваа зэрэг тэмцээнийг Өвөрхангай аймгийн нийт сумын бүх багийн дунд өргөн хэмжээнд зохион байгуулсан.





- ✓ Монгол Улсын шинэ харцага
Б.Цэдэнсодномд хүндэтгэл үзүүллээ.
- ✓ Аймгийн арслан Б.Галданцогтод хүндэтгэл
үзүүллээ.
- ✓ Монгол Улсын гавьяат тамирчин, Самбо
бөхийн дэлхий хошой аварга, Өвөрхангай
аймгийн Арвайхээр хотын уугул Баасанхүүгийн
Дамланпүрэвт хүндэтгэл үзүүлэн хамтран
ажиллалаа.
- ✓ Монгол улсын Волейболийн спортын шигшээ
багийн шилдэг хамгаалагч, спортын мастер,
нутгийн дүү Золбоотын Буянжаргалыг дэмжин
ажиллаж байна.
- ✓ Өвөрхангай аймгийн оюутан залуусын дунд
волейболийн тэмцээн зохион байгуулав.
- ✓ Өвөрхангай аймгийн Бар жилтний алдартан
шалгаруулж спортын өндөр амжилт гаргасан
залуучуудад хүндэтгэл үзүүлэн хүлээн авч, тв
нэвтрүүлэг бэлтгэн, гарын бэлэг гардуулав.
- ✓ Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд шагай
харваагаар хичээллэдэг хүүхдүүдэд зориулан
Шагай харвааны зурхай бэлэглэж Намрын
нээлтийн харваа тэмцээний зохион байгуулж,
Өвөрхангай, Баянхонгорын баг тамирчид өргөн
цар хүрээтэй оролцсон
- ✓ Өвөрхангай аймгийн нийт ахмадуудын дунд
ахмадын баярт зориулан Нумт харвааны
тэмцээн зохион байгуулав.
- ✓ Хайрхандулаан суманд морины зурхай, гараа
бэлэглэв.
- ✓ "НОЁД-2023" Өсвөрийн шатарчдын "Рапид"-ын
аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион
байгуулав.



СОЁЛ УРЛАГ

Урлаг, соёл бол надад бас ойр салбарын нэг л дээ. Сонирхлынхоо дагуу кино зохиол болон дууны үг хэд хэдийг бичсэн. Анхны кино зохиол маань "Трио" нэртэй уран сайхны кино болж, чамгүй амжилт үзүүллээ. Дуучин Б.Болд, Х.Мөнгөнцэцэг хоёртой хамтран хоёр ч дууны уран бүтээл бичсэн. Пянз цуглуулах хоббитой зэрэг энэ салбартай ойр байх шалтгаанууд дурдаж болно. Гол нь соёл урлагийн үйлчилгээ гэдэг орон нутагт байнгын хэрэгцээ нь байж байдаг зүйл л дээ. Ялангуяа ковидын хөл хорио цуцалсны дараа урлагийн тогтолц зохион байгуулахад сум нутгаараа цуглаж, хоорондоо хууч хөөрөөд нэг оройг сайхан өнгөрүүлсэн. Энэ үүднээс энэ жил "Дэлгэр зүн", "Налгар намар" урлаг, спортын цогц арга хэмжээ зохион байгуулсан нь олон нийтэд нэлээд хүрсэн.



НУТГИЙН БҮСГҮЙЧҮҮДИЙГ ДЭМЖИВ

Өдгөө бүхий л салбарт жендерийн мэдрэмжийг чухалчилдаг болсон. Тэр ч утгаар олон нийтийн жендерийн мэдлэгийг нэмэгдүүлэх үүднээс төр, хувийн хэвшил, төслийн байгууллагуудаас олон арга хэмжээ зохион байгуулж байна. "Алтангэрэл сан" Өвөрхангайн эмэгтэйчүүдийг дэмжих "Хангайн бүсгүйчүүд" ТББ-тай хамтран тэдний нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулав. Түүний дотор "Сарангва" эмэгтэйчүүдийн сэтгүүлийг эрхлэн гаргахад хамтран ажиллалаа.





ӨВӨРХАНГАЙН УРАН БҮТЭЭЛЧДИЙН ХАМТАРСАН "ТРИО" УРАН САЙХНЫ КИНО ОЛОН УЛСАД ГАРАВ

2023 онд Монголын кино урлагийн салбараас дотоод төдийгүй гадаадын үзэгчдийн анхаарлыг татсан нэгэн уран бүтээл мэндэлсэн нь "Трио" уран сайхны кино. Энэхүү бүтээл дэлхийн 5 тивээс 10 гаруй кино фестивальд шалгарсан, "Мөнгөн мод 2022" наадмын кино урлагийн Шилдэг бүтээлээр шалгарсан амжилт үзүүлээд байгаа юм. "Трио" уран сайхны киноны зохиолч О.Алтангэрэл хэлэхдээ, "Энэ кино манай өвөрхангайнхны кино гэж ойлгож болно. Багын найз Д.Баттөмөрийн маань анхны найруулсан, миний анхны бичсэн кино зохиол. Дээр нь манай киноны туслах дүр, зураг, хөгжим гээд олон зүйлд өвөрхангайн уран бүтээлчид оролцсон, Өвөрхангайн бүтээл юм" хэмээн тодотгосон. Олон улсаас шагналын хур буулгасан энэхүү бүтээлийг "Алтангэрэл сан"-гаас Өвөрхангай аймгийн ихэнх сумын иргэдэд үнэ төлбөргүй үзэж толилуулсан юм.



✓ Өвөрхангайн бүх аймаг сумдаар урлагийн тоглолтыг дуучин Б.Болд, Х.Мөнгөнцэцэгтэй хамтран зохион байгуулсан.

✓ Богд, Хархорин, Баян-Өндөр сумдаар намын гишүүд, иргэдтэй уулzan өмнө жил хийгдсэн ажил, цаашид сүм орон нутагт хийгдэвэл зохих үйл ажиллагаа иргэдийн санаа бодолтой танилцах мөн урлагийн тоглолтыг толилуулсан

✓ Өвөрхангай аймгийн нийт ахмадад зориулан Шашин урлагийн цэнгүүн зохион байгуулж нийт 500 гаруй ахмад хүрэлцэн ирсэн бөгөөд энэ үеэр тэдэнд хүндэтгэл үзүүллээ


✓ Өвөрхангай аймгийн багш, худалдаа эрхлэгчдэд урлагийн тоглолт үзүүлсэн.

✓ "Дэлгэр зун", "Налгар намар" арга хэмжээний хүрээнд Өвөрхангай аймгийн бүх сумдаар эрийн гурван наадам, спортын арга хэмжээ, урлагийн тоглолт зохион байгуулсан

МЭДЭЭЛЭЛ

2020 он

- ✓ "Боловсрол" хөтөлбөрийн хүрээнд элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэж буй сурагчдад онлайн сургалтыг зохион байгууллаа.
- ✓ Монгол улсын шинэ начин / харцага/ Б.Цэдэнсодномд хүндэтгэл үзүүллээ
- ✓ Өвөрхангай аймгийн сумдад хөнгөлөлттэй үнээр хивэг хүргэх ажлыг амжилттай гүйцэтгэлээ.
- ✓ Өвөрхангай аймгийн Богд, Баян-Өндөр, Өлзийт, Бүрд суманд Covid-19-ийн эсрэг шаардлагатай эм бэлдмэлийг гардууллаа
- ✓ Өвөрхангай аймгийн Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Бат-Өлзий, Уянга, Хархорин сумын эмнэлэгт амьсгалын аппарат бэлэглэв
- ✓ Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын ахмад настнуудад хүндэтгэл үзүүллээ.
- ✓ УИХ-ын гишүүн Б.Пүрэвдоржтой хамтран "Зөрчлийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ УИХ-ын гишүүн Н.Туваантай хамтран "Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Есөнзүйл, Арвайхээр, Хархорин сумын үер усны гамшигт өртсөн 5 өрхөд өргөө цагаан гэр бэлэглэв.
- ✓ УБ-ӨВ чиглэл дэх хамгийн их эвдрэл бүхий хэсэг замын засварыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэхээр "Зам, тээврийн хөгжлийн яам"-д албан хүсэлт гаргав.



2021 он



БОГД СУМ



- ✓ "Гэрэлт ирээдүй" сурагчдад боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд ахлах ангийн сурагчдын амралтыг тохиолдуулан 50 гаруй сурагчдад гарын бэлэг бэлэглэлээ.
- ✓ "Тэтгэлэгт оюутан" хөтөлбөрийн хүрээнд 3 сурагчид сургалтын төлбөр гардуулав.
- ✓ Өвөрхангай аймгийн сур харвааны холбоонд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллав
- ✓ Аймгийн арслан Б.Галданцогтод хүндэтгэл үзүүлэв
- ✓ Covid-19 Цар тахлын хүнд үед Өвөрхангай аймгийн Онцгой байдлын комисст HYANDAI маркийн автобус бэлэглэлээ.
- ✓ Covid-19 цар тахлын байдалтай холбоотойгоор Өвөрхангайн тодотголтой Улаанбаатар хотын оюутны байранд оршин суух нийт 100 гаруй оюутан сурагчдад хоол хүнсний болон мөнгөн туслалцаа үзүүллээ.
- ✓ Өвөрхангай аймгийн зарим сумын цэцэрлэгийн бяцхан сурагчдад шинэ жилийн бэлэг бэлэглэлээ.
- ✓ Богд, Баруунбаян-Улаан сумын онцгой комисс, эрүүл мэндийн төвд шаардлагатай эм бэлдмэл, шатахууны дэмжлэг үзүүллээ.

✓ УИХ-ын гишүүн Н.Ганибалтай хамтран "Хог хаягдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг өргөн барьсан.

✓ УИХ-ын гишүүн Адъяасүрэнтэй хамтран "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр" санаачлан хэрэгжүүлсэн. Мөн "Гэрч хохирогчийг хамгаалах тухай", "Гэр бүлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөл боловсруулан ажилласан.

✓ УИХ-ын гишүүн С.Одонтуяатай хамтран "Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн санал боловсруулсан.

✓ МУ-ын гавьяат тамирчин, Самбо бөхийн дэлхий хошой аварга, Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын уугуул Баасанхүүгийн Дамланпүрэвт хүндэтгэл үзүүлэн хамтран ажиллалаа

✓ Монгол улсын Волейболын спортын шигшээ багийн шилдэг хамгаалагч, спортын мастер, нутгийн дүү Золбоотын Буянжаргалыг дэмжин хүндэтгэл үзүүлж, хамтран ажиллаж байна.



- ✓ Өвөрхангай аймгийн Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Бат-Өлзий, Уянга, Хархорин сумын сургуулийн химиийн хичээлийн танхимд сургалтын хэрэглэгдэхүүн бэлэглэв
- ✓ Залуу уяачдыг сургах зорилгоор улсын манлай уяач Г.Батчулууны "Хурдан морины уяа, сойлго" лекцийг Өвөрхангай аймгийн бүх сумдаар зохион байгууллаа.
- ✓ Залуу дуучин Болд, Мөнгөнцэцэг нартай хамтран ажиллаж, Өвөрхангай аймгийн бүх сумдаар урлагийн тоглолт зохион байгуулав
- ✓ "ITU" мэдээллийн технологийн салбарыг ахлах ангийн сурагчдад таниулахад зориулсан цуврал лекц, хөгжөөнт сургалтыг Өвөрхангай Аймгийн Арвайхээр болон Хархорин хотод амжилттай зохион байгуулсан.
- ✓ Зүүнбаян-Улаан суманд Алтангэрэл сан, Ардчилал академитэй хамтран төрийн албан хаагчдад зориулсан хувь хүний хөгжил манлайллыг дэмжих сургалтыг зохион байгууллаа.
- ✓ Хархорин сумыг "хот"-ын статустай болгох төсөлт ажлыг зохион байгуулан 1500 гаруй иргэний гарын үсэг цуглуулан Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, УИХ-ын дарга Г.Занданшатар нарт гардуулсан
- ✓ Өвөрхангай аймаг байгуулагдсаны түүхт 90, 91 жилийн ойн баярыг тохиолдуулан 90 хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлэглэсэн.
- ✓ Өвөрхангай аймгийн ТМС-ийн байрны гадаад талбайн хүүхдийн тоглоом зэргийг засан сайжруулж, шинэ тоглоом байрлуулсан
- ✓ Зүүнбаян-Улаан сумын сургуулийн сурагчдын дотуур байранд "Хүүхэд хөгжлийн өрөө" бүрэн засвар хийж тохижуулж өгсөн
- ✓ Өвөрхангай аймгийн нийт сумдад 1-12 ангийн хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулсан
- ✓ Богд, Төгрөг сумын галд өртсөн 2 айлд гэр бэлэглэсэн

2022 он



2023 он



СУРВАЛЖИЛГА



Аз ЖАРГАЛДААР ӨРСӨН АМЬДРАЛ

Амьдралыг барилга гэвэл өрж босгосон тоосго нь аз жаргал юм уу гэмээр сайхан гэр бүл байх. Тийм сайхан гэр бүлийг сурвалжлахаар Өвөрхангай аймгийн Төгрөг сумын зорьж очлоо. Танихгүй айлд оройтож очсондоо гэмшингүй буутал том охин нь хашааны хаалган дээрээсээ уриалгахан тосов. Саяхан хонь гаргасан бололтой гэдэс гал дээрээ өрдсөн, халуу дүүгэсэн гэр угтав. Гэрийн эзэгтэй буузны мах татаж сууна. Найман хүүхэдтэй өнөр өтгөн айл гэдгийг нь би мэдэж байсан хэрнэ орсон даруйдаа хүүхдүүдийнх нь тоонд төөрч хэсэгтээ хэн нь хэн билээ гэж ээжээс нь хэдэнтээ асуув. Би товлосон хугацаанаасаа хоцорч очсон тул гэрийн эзэн Д.Батдорж ажилдаа яваад эзгүй байв.

Хөдөөгийнхөн бүрэг, дээрээс нь манай өвөрхангайхан "өөтийм үү хө" гээд уянгалуулсан шигээ суудаг тайван ч юм шиг, найрсаг ч юм шиг шиг ард түмэн. Хүүхдүүд номхон команд авсан мэт томоотой сууцгаана. Гэрийн эзэгтэй Ч.Мөнгөнжигүүрийг ажлаа дуусахыг хүлээх хооронд хажууд суугаа 2-оос асуув.

Та хоёр хэддүгээр анги вэ?

Энэ цэцэрлэг, би 1-р анги гээд намайг сониучирхан өөдөөс хараад суугаа дэrsийн хоёр хүүхдийн эгч нь хариулав. Эдний хүүхдүүд бүгд голдуу хоёр насын зөрүүтэй. Цэцэрлэгийн насын хоёр, тэгээд 1, 5, 7, 9, 11-р ангийн таван сурагч, хамгийн том хүү нь одоо 2-р курсийн оюутан.

Энэ мэт ойр зуур ярьж суутал энэ гэрийн "эзэн хаан" сэргээд дээ. Том багагүй хошуу дэвсээд сүйд. Өөрийнх нь дээд талын цэцэрлэгийн ах хүртэл дүүгээ өхөөрдөөд, хэл нь халтираад ирэв. Гэвч өнөө бага наймын найман ах эгчтэй гээд эрхээрээ хатаад, савж унаад уйлаад унах нь уу гэлэл үгүй ээ. Охин хэрнэ эршүүд гэж жигтэйхэн. Хэдий говь ч гэлээ намрын сүүл сарын хувьсгануур цаг агаартай тэнгэр дор хагас нүцгэн л гүйгээд байх. "Зун бол хувцас өмсөнө гэж байхгүй" гэж ээж нь нэмж хэлэв. "Хөрслөг бор охин байна даа" гэхэд "Харин ч цайчиhaад байгаа нь энэ" л гэнэ.

Ч.Мөнгөнсоёмбо хоол ундны ажлаа хоёр том охиндоо шилжүүлчихээд хажууд суув.

Найман хүүхэдтэй ч залуу гэр бүл байна. Анхны хүүхдээ хэдтэйдээ төрүүлэв?

18-тайдаа анх ээж болсон. Нөхөр бид хоёр 2003 онд гэр бүл болсноос хойш одоо ингээд ам бүл арвуулаа болчихоод байж байна.

Найман хүүхэдтэй, найман ханатай гэртэй сайхан бэлгэдэлтэй юм.

Бургасан ханатай, 8 ханат энэ гэрийг О.Алтангэрэл дарга бэлэглэсэн. Өнгөрсөн жилийн наймдугаар сард би оюутан хүүгээ хот хүргэж өгөхөөр яваад, нөхөр маань айлд гагнуур хийгээд эзгүй хойгуур гэрт гал гарч, хайлсан юм. Тэр үеэр хүүхдүүд маань азаар миний үеэл Ц.Бямба-Отгон цолны найраа хийгээд барьсан байсан гэрт тоглож байсан юм билээ.



Айхтар юм болж. Юунаас болж гал гарсан юм бол?

Утасны масснаас болсон юм билээ. Тэгээд бид айлын гэрт хэсэг байж байтал дараа сард нь О.Алтангэрэл дарга гэр өгнө гэхээр нь бөөн баяр. Доторх тавилгыг нь бас манай сумын АН-ын гишүүд нийлж авч өгсөн. Энэ хүмүүсийн ач буянаар сайхан өргөө гэртээ болсон.

Та улсын гарьд Ц.Бямба-Отгоны үеэл гэсэн гэв үү? Тэгэхээр барилддаг удам байх нь уу?

Ээжийн дүүгийн хүүхдүүд барилддаг. Сая болсон Азийн аваргын пара олимпийн төрөлд ээжийн нэг дүүгийн хүү оролцсон. Манай том хүү "Бямба-Отгон ах 20 нас гарч барилдаж эхэлсэн юм чинь хойтон би сумын 100 жилээрээ

барилдаж эхэлнэ" л гээд байгаа. Ноднин хэдэн сар Бямба-Отгон ахтайгаа амьдарсан юм. Тэр нь их нөлөөлсөн шиг байна лээ. Энэ дунд хүү ч ноцолдох л сонирхолтой. Хэдэн эмэгтэй дүүтэйгээ ноцолдоод, ширүүдчих гээд байх юм. Ээжийн тал бөхийн удамтайгаас гадна манай хадам аав бас сумын начин хүн байдаг.

Ер нь танай хүүхдүүд их нуруулаг юм.

Өө бөөн волеволчид. Урлагаараа ч сайн. Цөм дуулна. Манай ээжийн тал сайхан дуулдаг. Том охин удахгүй аймагт болох уртын дууны тэмцээнд орох гээд бэлдэж байгаа. Урлагийн үзлэгийг манай хүүхдүүд гаргаахгүй шүү дээ. Ес юм шиг л нэгт орно.

Ээжийг тэгж хэлэхтэй зэрэгцэн



дунд охин дуу эхэлтэл том жижиггүй дуулж байна. Том охины уртын дууны сургуулитын бичлэгийг үзэхэд үнэхээр цангинаж байна лээ. "Нөхөр бид хоёр боловсролгүй болохоор бүгдийг нь боловсролтой болоход анхаардаг. Манай хэд сурлагадаа ч сайн. Ер нь аав ээжийнхээ хийгээгүй болгоныг хийж явааг харах сайхан байдаг" гэж Ч.Мөнгөнжигүүр хэлсэн.

Эдний хамгийн сахилгагүй нь доороосоо хоёрдахь хүү. Харваас бага дүүгээсээ илүү эрх байрын нөхөр байна. Харин хамгийн даруухан нь дээрээсээ 3 дахь охин Оюунбилэг гэнэ. Ээж нь хот явахаар болж бага дүүг нь харуулахаар Оюунбилэгийг авч явах болоход дунд охин "Та дандаа яагаад Оогий аниаг авч явдаг юм. Би бас явмаар л байна шүү дээ" гэхэд "Дүүгээ сайн хардаг болохоор" гэв. Харин том эгчээс бол дүү нар бүгд айна.

Ээжийн үгийг бол нэг их тоохгүй шинжтэй. Ээж үг хэлж л байна, багачууд бужигнаж л байна.

Харин том эгч босоод ирвэл бүгд нам болно. Эднийх хүүхдүүддээ барагтай бол зурагт үзүүлж, утсаар оролдуулдаггүй. Угаасаа ч дэrsийн найман хүүхэд дунд уйдаад байхаар ч үгүй билээ.

"Бужигнаж байтал нэг мэдэхэд өдөр өнгөрчихдэг юм. Тэгээд ч утас, зурагт их үзсэн хүүхдийн ааш эвдрээд байдаг" гэж ээж нь хэлсэн. Ер нь эдний хүүхдүүд бага нь томынхоо үгнээс гардаггүй, том жижиг гэлтгүй чадах чадах ажлаа хийгээд явчихдаг, сайхан хүмүүжилтэй юм. "Хүүхдүүдээ цэвэрч нямбай, орсон гарсанд ундтай устай байлгах юмсан гэж боддог" хэмээн Ч.Мөнгөнжигүүр хэлсэн шигээ зочиндоо эхэлж зоогоо барьдаг, ёс төртэй, цэмбийсэн айл байна лээ.

Хайраар халуу дүүгэсэн ийм нэг өнөр айл аз жаргал хэмээх тоосгоор амьдралаа өрж сууна лээ.





Б.ОРХОН: АЯЛЛААС ОЛОН ЗҮЙЛИЙГ ОЛЖ АВДАГ. НЭГ Л ЗҮЙЛИЙГ ХАЯДАГ. ТЭР НЬ

ЭГД

Өвөрхангай аймагт нутаг орондоо төдийгүй, улсдаа үлгэр жишээ болох олон сайхан хөдөлмөрч хүмүүс бий. Тэдний нэг бол Хужирт сумын иргэн, өрхийн тариалагч, англи хэлний хөтөч орчуулагч гээд яривал олон гуншинтай Б.Орхон юм. Түүнтэй ярилцсанaa хүргэе.

■ Таны талаарх анхны мэдээлэл их олон төрлийн ажил хийдэг хүн гэдэг нь сонирхолтой санагдсан?

Олон төрлийн зүйл хийж чадаж байна гэдэг бол ардчиллын л буян. Дуртай газраа амьдарч, дуртай газраа аялж, дуртай хөдөлмөрөө хийж байна. Өөрийнхөө хийе гэсэн болгоноо би ардчиллын буянд л олж авсан. Үүний хүчинд би өдийд хүний зэрэгтэй явна гэж боддог.

■ Таны үндсэн мэргэжил юу вэ?

Малчин. Малчин гэхээр хүмүүс мэргэжилгүй юм байна гээд шоолонгуй ханддаг. Тийм биш.

Харин ч энэ бол хамгийн чухал мэргэжил. Энэ мэргэжилд юм бүхэн хамаарна. Байгаль ахуйгаасаа эхлээд өргөн хүрээнд судалгаа хийж байж ажилладаг мэргэжлийг малчин гэдэг. Хамгийн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж чаддаг үйлдвэрлэлийн эзэн бол малчин хүн.

Хоббиныхоо дагуу англи хэл сонирхож судалсан. "Газарчин" дээд сургуулийг 4 жил сурч төгсөөд, англи хэлний орчуулагч, хөтөч мэргэжил эзэмшсэн. Түүнээс 15-16 жил энэ ажлаа хийж байна. Энэ бол зүгээр миний хобби. Хүмүүс маш их хөдөлмөрлөж байж, хураасан мөнгөөрөө аялдаг. Харин би мөнгө олонгоо аялдаг.

Бас нэг дуртай хобби бол мод тарих. 5000 гаруй мод гэр бүлээрээ тарьсан. Жилдээ 5 тонн гаргаж чацарагана авдаг. Чацараганы аж ахуй бол монгол хүн бурийн хийж хэрэгжүүлж болох зүйл. Монгол хүн болгонд

байгаа баялаг бол газар. Газар гэдэг саалийн үнээг саах уу, тэр чигт нь хаях уу гэдэг бол хувь хүний асуудал. Би гэр булийнхээ хэмжээнд 4 га газрыг тусгай хамгаалалттай газартай нөхөн сэргээлт хийх гэрээ хийж, тариалалт хийж эхэлсэн. Сум орон нутгийн удирдлагууд бол дэмжээгүй. Намайг тэр газрыг авах гэж байна гэж хардсан. Хүн гэдэг бодьгал энэ хорвоогоос явахдаа 2-хон га газар л өмхийруулдаг байхгүй юу. Өөр үлдэх юм байдаггүй. Харин мод тарьсан байхад экологио тэнцвэржүүлж, ирээдүйд үр хүүхэддээ эрүүл байгаль үлдээнэ. Эхлээд байгаль дэлхийдээ өгсөн байхад эргээд байгаль дэлхий бидэнд хэд дахин давуулаад өгдөг. Мал аж ахуй ч яг тийм. Бид байгалиасаа дандаа авдаг. Хэзээ ч буцааж өгдөггүй. Та амьдралдаа хэр их хүчилтөрөгч амьсалаад, хэр их нүүрстөрөгч болгон гаргаж бохирдуулсан бэ гээд ярих юм бол бидний хийсэн гэмт хэрэг нэлээд болно шүү.

“

Нутгийн хүмүүсээр кг тутамдаа 4000 төгрөгөөр хураалт хийлгэдэг. Тэтгэврийн хөгшид ирж хураалт хийгээд, өдөртөө 100-120 мянган төгрөг аваад яваад өгдөг. Гэтэл залуус хийдэггүй. Энэ ажил жижигдээд байна гэнэ. Тэгсэн хэрнэ эмээ өвөөг цалингаа авчихаар хажуугаас нь манай хүүхдүүдэд юм авч өг, надад бинзений мөнгө өг гэдэг. Сүүлийн үеийн залуусын бодол бол гэнэтхэн их мөнгө зүгээр байж байгаад л олно гэдэг мөрөөдөлтэй. Манайх 3 тн орчим төмс, 5 тонн чацаргана, байгалийн ногоон өвс 10-аад тонн, тэжээлийн солом бас 5-6 тонн гаргаж авдаг.

”

Уусан ус, амьсгалсан агаар, энэ бүхнийг бодохоор бид тэр өрөө төлөх ёстой. Тэгэхийн тулд мод тарих ёстой. Олон төрлийн мод тарьж болно. Тэр дундаас бид жимснийхээ модыг тарьчих юм бол органик бүтээгдэхүүнээр дэлхийн төвшинд гарах боломж байна. 4 г-гаас 5 тонн жилдээ аваад гэр бүлийн хэрэгцээнд хамгийн дээд тал нь 50 кг зарцуулдаг. Бусдыг нь борлуулах зах зээл муутай. Тэр засгийн жаахан зөв менежмент байвал уг нь бид хийгээд байна.

■ Та жимсээ яаж борлуулж байна?

Хүн бүрийг аваач гээд л гуйна даа. Суман дахь төрийн байгууллагууд уг нь авах хэрэгцээ байгаа ч хэдхэн хүний бизнес орчихдог. Нутгийн хүмүүсээр кг тутамдаа 4000 төгрөгөөр хураалт хийлгэдэг. Тэтгэврийн хөгшид ирж хураалт хийгээд, өдөртөө 100-120 мянган төгрөг аваад яваад өгдөг. Гэтэл залуус хийдэгтүй. Энэ ажил жижигдээд байна

гэнэ. Тэгсэн хэрнэ эмээ өвөөг цалингаа авчихаар хажуугаас нь манай хүүхдүүдэд юм авч өг, надад бинзений мөнгө өг гэдэг. Сүүлийн үеийн залуусын бодол бол гэнэтхэн их мөнгө зүгээр байж байгаад л олно гэдэг мөрөөдөлтэй. Манайх 3 тн орчим төмс, 5 тонн чацаргана, байгалийн ногоон өвс 10-аад тонн, тэжээлийн солом бас 5-6 тонн гаргаж авдаг.

■ Сэдвээ өөрчлөөд хэл хэрхэн сурсан талаар сонирхоё?

29-той хөгшин оюутан их сургуульд элссэн. Манай ангийнхан 10 жилдээ үзчихсэн, тачигнатаал англиар ярина. Багш даалгавар өгнө нөгөөдүүл чинь хийчхээд, пижигнэтэл гараад явчихна. Би юу ч ойлгохгүй үхэр шиг суугаад л үлдэнэ. Эхний хэдэн сар нүүрээ хийх газаргүй болтлоо ичдэг байсан. Тэр хэмжээгээрээ өөрийгөө хурцалж бие дааж их үзсэн. Эхний жил навс чирэгдээд, хоёр дахь жилдээ дөхөж очоод, гуравдахь жилдээ ана мана болоод, 4 дөх жилдээ 120 хүүхдээс 2 хүүхэд шалгаруулж авах ажилд тэнцэж байсан. Ингээд хавар төгсөхөөсөө өмнө жуулчны компанид хэлмэрч орчуулагчаар ажилд орсон. Түүнээс хойш тасралтгүй хэлмэрчээр ажилласан. Өвөлдөө сумын төв дээр ярианы англи хэл зааж өгөөч гэсэн хүсэлт найз нөхөд маань тавиад зааж эхэлсэн. Түүнээс хойш 5-6 жил хийчихлээ. 100 нэлээд гаран шавьтай.

■ Англи хэл сурья гэж яагаад тэгж их зорив?

Анхны хань маань бурхан болсны дараа цаашдаа яах вэ гэж өөрөөсөө асуусан. Хaa нэг газарт

ажиллаад явахад би хүүхдээ өлсгөхгүй, дааруулахгүй, гэхдээ нэг хүний барлаг хийгээд явна. Хүний заасан цаг хугацаанд л хүний хэмжиж өгсөн мөнгөнд амьдарна. Тэгэхгүй тулд би юу хийх вэ гэхээр хамгийн боломжтой зам нь надад хэл сурх санагдсан. Тэр 4 жил бол надад үнэндээ чанга байсан, гэхдээ би маш сайн сурсан. Хэлтэй болоод ажилд орсон, манай хүү ч намайг дагаж явсаар 13-тайгаасаа хөтөч болсон. Хэлийг эрт сурх тусам хүүхэд мөнгө олж, хүнтэй харилцаад сурдаг. Сүүлийн үеийн залуусыг харахад ажил хийх хэрэгтэй байдаг. Гэтэл сурсан мэдсэн зүйл нь амьдрал дээр гарч ирэхгүй, мөнгөө олж чадахгүй байхаар түүндээ маш стресстэж байна. Гэтэл багаасаа өөрөө мөнгө олоод хөдөлмөрлөөд сурсан хүүхэд стресстэггүй. Хэл яагаад сурх ёстой шалтгааныг би сургалтад суудаг хүүхдүүддээ хэлж өгдөг учраас түргэн ч сурдаг, ажлын гараагаа хурдан эхэлдэг. Шавь нарын маань тэр амжилт надад их урам өгдөг.

■ Малчин болсон тухайд?

ЕБС-ээ төгсөөд, тухайн үед Ахуй үйлчилгээний техникум гэж байсан. Түүнийг гуталчнаар төгссөн ч ажлын ажлын байр байгаагүй. Ганц боломжтой ажлын байр маань малчин байсан. Ингээд мал маллаж байгаад 2003 онд амьдралд маань өөрчлөлт ороод, оны сүүлээр хот руу ороод, 2004 онд оюутан болсон. Ингээд 2008 оноос хойш завсаргүй орчуулагч хөтөч хийсэн. 2016 онд чацарганы талбайд тариалалтаа хийж эхэлсэн. Зундаа орчуулагчаа, өвөлдөө

англи хэлний сургалтаа хийдэг байж байгаад ковидын жил сургалт, аялал жуулчлал байхгүй болоод эхлэхээр буцаад малчин болсон. Одоо 200 гаруй малтай. Энэ бүхэн ерөөсөө арчиллын буянаар бий болсон эд шүү дээ. Өмнө нь хүний мал маллаж, хүний ажил хийж байсан. Цалин авч байсан уу, хүний хэмжиж өгсөн хэдхэн төгрөг дотор амьдарч байсан. Хэзээ ч өөрийн дураар малаа зараад, машин унах эрх чөлөө өмнө нь байгаагүй. Энэ бүхэн арчиллын буянаар бий болсон.

■ **Өрхийн үйлдвэрлэлд хүнийг олж авахаас гадна ажиллуулна гэдэг их арга эв шаардана биз?**

Хэлмэрч гэдэг бол хүний сэтгэхүй дээр хийдэг ажил. Харахад орчуулаад байгаа мэт хэрнээ цаад хүн ойлгож байна уу, хүлээж авч байна уу гэдгийг нь мэдэрч байж орчуулга хийдэг. Тэгэхгүйгээр би энд мянга юм яриад л байдаг, өнөө хүн өөр тийшээ хараад байвал амьд харилцаа үүсэхгүй. Яаж амьд харилцаа үүсгэх вэ гэдэг орчуулагчийн ур чадвараас шалтгаалдаг. Тайлбарлаж байгаа тухайн зүйлийнхээ талаар тэр хүний сэтгэхүйд буутал ярих ёстой. Мэдээллийн урсгал их болсон энэ үед миний ярьсан зүйл давж үлдэх үү гэдэг бас орчуулагчийн чадвар. Хэлмэрч мэргэжлээс сурсан нэг зүйл бол харилцааны чадвар юм шиг байгаа юм.

■ **Одоо жуулчдаа ямар шугамаар авч байна?**

Заримдаа хувь шугам, заримдаа компани, таньдаг найз нөхдийн шугамаар гээд янз бүр. Найз

нөхдийн хүрээ нэлээд өргөн болсон учраас тэднээс их ирдэг. Хэлтэй болсны буянд жишээ нь Канадад "Хоёр талын нислэгийг чинь даая, сайхан аялаад буц" гэсэн урилга хүртэл өгдөг хүмүүс байдаг. Надад гадаадад байна гэдэг хэцүү, эх орон л сайхан. Аяллаар жилд 50 мянган км явах үе байна. Сайн гүйлттэй эмнэлгийн тэрэг жилдээ 30 мянгатай байдаг гэсэн.

■ **Та уулчин уу. Таны фэйсбүүкт авиралт хийж байгаа зургууд харсан?**

Зүгээр хобби. "Анх уул руу авирдаг хүмүүсийг хараад шал тэнэг юм, гарчхаад буцаад ирэхийн хооронд" гэж боддог байсан. Гэтэл энэ бол өөртэйгээ хийдэг тэмцэл юм билээ. Залхуурах, айх, итгэлгүй байх гээд сэтгэлийн сөрөг чанар бүхнээ давж гарсан хүн л уул руу гардаг. Уулын оргил дээр гараад "Би чадлаа даа" гээд зогсож байхад дараагийн ажилд бол ер түүртэхгүй. Ер нь амьдралд баргийн юманд нугарахгүй болдог. Анхны авиралт бол бүр аймшигтай байсан. Хүчилтөрөгчийн дутагдалд ороод чих шуугиад хэвтчихсэн. Гэсэн ч бага багаар дөхсөөр байгаад оргил дээр гартал цээжнээс нэг юм хөөрөөд, амаар гараад явчих шиг манас хийгээд сонин болсон. Үүнээс хойш би баргийн юманд шантрахгүй юм байна гэдгээ мэдсэн.

■ **Анхны авиралт хэдэн онд байв?**

2014 онд анхны авиралт хийсэн. Монголд авиралт хийхээр ирсэн хоёр жуулчинтай явж байсан. "Гаднын хүн ирчхээд авираад байхад би замынхаа дундаас

буцаад байхдаа яадаг юм" гэсэн бодлоор л анх авирсан. Тэгээд ч уул хаачхаад, Оросын нутаг цаана нь харагдахгүй байсан болохоор үүний цаана юу байгаа бол гэдэг хүсэл байсан. Түүнээс хойш б удаа ууланд авирахад тэнгэр цэлмэг өдөр ч таарсан, заримдаа цасан шуургатай хэцүү өдөр ч байсан. Тэр болгоноос сургамж, давтагдашгүй шинэ мэдрэмж авдаг. Улам хөнгөрөөд, өөртөө итгэлтэй зоригтой болдог юм билээ. Б.Гангаамаа гавьяаттай ууланд хамт авирч, сургалтад нь сууж байсан.

Аялна гэдэг бол маш олон хүнтэй танилцаж, олон төрлийн мэдээлэл авч, тэр хэрээр эгогоо хаядаг зүйл.

■ **Цаашдын зорилго?**

Гаднын зах зээл дээр маш их хөрөнгө байдаг. Тэрийг эх орондоо оруулж ирмээр байна. Жишээ нь Туркууд Монголд ирээд өвөг дээдсийнхээ хөшөөнд мөргөөд сүйд болдог. Тэгвэл энэ урсгалыг бий болгосон аялал жуулчлалын боломжийг яагаад нээж болохгүй гэж. Аливааг хийж бүтээгээд ирэхээр зорилго улам томордог юм байна. Өвөрхангай аймаг, цаашлаад улс эх орныхоо төлөө зүйл хиймээр байна. Энэ зорилгоор 2020 онд АН-аас сумын ИТХ-д сонгогдсон. Аймгийн ИТХ-д 53 хүний саналаар дутсан.

Миний улс төрийн болоод олон нийтийн ажлыг О.Алтангэрэл дарга маань дэмждэг. Ер нь удирдах арга барил сайтай хүн шүү дээ.

19 СУМ ӨНГӨ

Бат-Өлзийд амьдардаг дүүтэйгээ цахимаар ярж байтал хажуугаас бага охин нь орж ирээд, “Өнөөдөр цэцэрлэг надад гутал өгсөн” гээд харуулж байна. Дүү “Аа өнөөдөр харин “Алтангэрэл сан” гэнэ үү, тийм газраас цэцэрлэгийн бүх хүүхдэд гутал бэлэглэсэн гэнэ ээ” хэмээн ярж байснаа “Өө сая таны яриад байсан Алтангэрэл юм уу” гээд асуултаа асуултаар хариулав.

Энэ мэт хүн рүү нь чиглэсэн материаллаг болон оюун санааны хөрөнгө оруулалтыг О.Алтангэрэл олон хийсэн. Магадгүй тэдний олонхи нь манай дүү шиг хэнээс ирсэн хандив, тус гэдгийг мэдэхгүй өнгөрнө. Тус иймдээ л үнэ цэнтэй. Эзнээ зарлаж алдаршуулах зорилготой тус бол ондоо ойлголт. Цагаа, нудээ олсон тус гэдэг хэмжээнээсээ үл хамаарч магадгүй тухайн хүн насан туршаа мартахгүй ач санах үнэ цэн болж үлддэг. Тэр дундаа эрхэзүйн мэдлэг дутмагаас асуудалд орж, “Дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болсон” иргэдэд хуульзүйн үнэгүй тусламж өгч, гарцыг нь зааж өгөх шиг том тус гэж юу байхав.



С.ЦОГТБААТАР

Нарийнтээл сумын АН-ын дарга

Өнгөрсөн хугацаанд нутаг орондоо сайн ажилласан гэж боддог. УИХ-ын гишүүдээс илүү ажиллалаа гэж хүмүүс ярж байна. Гол нь Алтангэрэл дарга эргэх холбоо сайтай, асуудлыг цаг алдалгүй шийдэж, гарц гаргалгааг нь хэлж өгдөг. Хуульчийнхаа хувьд эрх нь зөрчигдэж байгаа хүмүүстэй уулзаж, хуульзүйн тусламж байнга үзүүлдэг. Тиймээс орон нутгийн иргэдийн дунд нэр хүнд сайтай хүн.



Т.СЭЭСРЭГДОРЖ

Гучин-Ус сумын малчин

О.Алтангэрэлийн нутаг орондоо явуулж байгаа ажил нь их зөв зүйтэй санагддаг. Янз бүрийн асуудалд холбогдоогүй, нэр цэвэр, боловсролтой хүн юм байна гээд таарсан хүндээ ярж л байдаг юм. Зөв залуусаа дэмжих нь бидний ирээдүйд л хэрэгтэй юм даа.



Ж.ГҮНГЭЭБҮУ

Богд сумын Засаг дарга

О.Алтангэрэл дарга Өвөрхангай аймагт намынхаа нөхдийг үлгэрлэж, манлайлдаг, сайн зохион байгуулагч гэж боддог. Манай сумын хувьд өнгөрсөн хугацаанд нягт уялдаа холбоотой ажилласаар ирсэн. Төрийн албан хаагчид болон ард иргэдийн нийгмийн

асуудлыг шийдэх ажлыг их хийдэг. Сүүлд зохион байгуулсан арга хэмжээнээс дурдвал Багийн дарга нарын бүсчилсэн уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулсан нь орон нутгийн хөгжилд хэрэгтэй зүйл байсан. Богд суманд 4 аймгийн уяачид оролцсон “Ялалт- 30” баяр наадам хийснээс гадна бусад сумдад бас зохион байгуулсан “Дэлгэр зун 2023” урлаг соёлын арга хэмжээг мөн хийсэн.



Б.ОЮУН

Уянга сумын ЕБС-ийн багш

Алтангэрэл маань сум орон нутгийнхaa ард иргэдийн сайн, сайхны төлөө байнга санаа тавьж, төрөлх сумандaa "Өлзий Орших" ахмадын төвийг байгуулан ахмад настангууд өдрийг тав тухтай өнгөрөөх сайхан газрыг байгуулан ажиллуулж, хэлэх үгтэй хийсэн ажилтай, шударга үнэний төлөө дуугарч байдаг төлөв төвшин сайн залуу. Сурч байсан сургуульдаа түүхийн кабинет тохижуулан өгч багш нарынхаа хичээл заах, сургач дүү нарынхаа сурч, хөгжих таатай орчин бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсанд сургуулийн хамт олон, багшийн зүгээс маш их баяртай байдаг. Цаашдын ажил, амьдралын алтан шар зам нь өлзийтэй байхыг ерөө.



Д.АМИЙДАА

Хархорин сумын ЕБС-ийн сургач

ITU мэдээлэл технологийн сургалтад хамрагдсанаар би IT чиглэлээр цаашид сурах хүсэл маань улам тодорхой болсон. Үүн шиг сонирхолтой сургалт орон нутагт тэр бүр болоод байдаггүй. Үеийнхээ төгсөх ангийн хүүхдүүдтэй хамт нэг өдрийг хөгжилтэй байдааар шинэ мэдээлэл, мэдлэг олж авсандаа баяртай байна. Энэ сургалтыг зохион байгуулсан "Алтангэрэл сан"-д баярлалаа.



М.ТӨРБОЛД

Тарагт сумын хувиараа бизнес эрхлэгч

О.Алтангэрэл дарга зөвхөн Тарагт гэлтгүй бүх суманд малчин, ахмадууд, багш, эмч гээд бүхий л салбарт чиглэсэн ажил зохион

байгуулсан. Сум орноос тавьсан саналыг хувь иргэнийх гэлтгүй уриалгахан шийдэж өгдөг. Хуульчийнхаа хувьд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг. Ер нь асуудал тавихад дор дор нь шийдэж өгдөг. Өөрөө шийдэх боломжгүй бол өөр хүнтэй холбоод өгдөг. Залуу хүн учраас хурдтай. Бага насаа Тарагтад өнгөрөөсөн учраас элэгтэй байдаг.



Г.ДААРИЙМАА

Бат-Өлзий сумын ЕБС-ийн багш

ЕБС-ийн багш нарын хувьд үндсэн ажлаас гадна бичиг цаасны ажил их, ер нь ачаалал ихтэй л дээ. Ар гэр, нийгмийн асуудал тэр хэрээрээ л хаягдаж байгаа юм. Өнгөрсөн зүн "Алтангэрэл сан"-гаас манай сургуулийн багш нарыг хүлээн авч уулзаж, сувиллын газарт амруулсан. Тэр үеэр Алтангэрэл даргатай уулзахад, суурь боловсролын үнэ цэнийг ойлгодог, багш нарын хөгжлийг

дэмждэг ухаалаг хүн санагдсан. Ер нь манай сум гэлтгүй Өвөрхангайн боловсролын салбарт их олон ажил хийсэн хүн шиг байна лээ. Нийт багш нарынхаа өмнөөс энэ салбарт үргэлж хөрөнгө оруулдагт талархаж буйгаа илэрхийлээд, ажлын амжилт хүсье.



Ц.ДОРЖСЭМБЭ

Өлзийт сумын малчин

Хуульчийнхаа хувьд ч улс төрчийнхөө хувьд ч их ирээдүйтэй залуу гэж хардаг. Сая манай sumaар явж малчдыг эмнэлгийн үзлэгт хамруулсан нь бидэн шиг хээр хөдөө явж байдаг хүмүүст хэрэгтэй үйлчилгээ болсон. Эмийн сан хүртэл дагуулж ирсэн нь их аятайхан юм болсон.



Г.МАШБАТ

Хужирт сумын иргэн,
соёлын тэргүүний ажилтан

Залуу хүн гэхэд хэлэх
үг, хийсэн ажилтай,
бие даасан хүн байна
лээ. Ард түмнийг
албан ёсоор төрд
төлөөлөгчийг хэрнээ сум
орон нутагтаа ингэж
ажиллана гэдэг чинь
мундаг байхгүй юу.
Ирээдүйтэй залуу байна
даа гэж харсан.

сурагтай. Гэхдээ нутаг
оронтойгоо байнга
холбоотой байдаг юм.
Зорьж байгаа ажлынхаа
ард гардаг, хуульч
эрхзүйн мэдлэг сайтай,
нутгийн ийм хүүхэд
цаашдаа ч их зүйл
хийнэ дээ.

ч тойрогтоо тогтмол
ажилладаг. Иргэдтэй их
оир ажилладаг учраас
орон нутагт тулгамддаг
асуудлыг сайн мэддэг.
Ард иргэдээ төлөөлөх
хүн ер нь их сайн хуульч
байх хэрэгтэй юм
байна гэдгийг түүнээс
харж байна. Хуульч
хүний нүдээр нийгмийн
асуудлыг харах, шийдэх
нь үр дүнгийн хувьд их
өөр байдаг.

иргэдийг цалинжуулан
ажиллуулсан. Ийнхүү
нугийн маань байгаль
орчныг нөхөн сэргээх
ажилд үнэтэй хувь
нэмэр оруулсанд манай
сумынхан талархалтай
байдаг. Энэ мэт нутаг
оронд маань нүдээ
олсон олон төрлийн
ажил зохион байгуулж,
үргэлж бидний ажлыг
дэмжиж, хамтран
ажилладагт нь баярлаж
явдаг.



Д.ГЭРЭЛСҮРЭН

Бүрд сумын 4-р багийн засаг
дарга

О.Алтангэрэл даргын
хийж байгаа ажлууд их
зөв зүйтэй санагддаг.
Хүнийхээ хувьд ч зөв
бодолтой. Тиймээс
бүхий л арга хэмжээг нь
дэмждэг. Сая дэлгэцээр
гарсан "Трио" кинонд
манай сумын хүүхэд
тогlossen.



Д.БААТАРЧУЛУУН

Баруунбаян-Улаан сумын
Засаг дарга

Баруунбаян-Улаан
сум цөлжилт, элсний
нүүдэл ихтэй. Сумын
төвийн хойд хэсгийг
битүү ойн зурvas болгох
ажлыг 10 жилийн
өмнөөс төлөвлөж
байсан. Загаа өөрсдөө
үрслүүлж тариход
бортог үнэтэй учраас
туслалцаа үзүүлнэ
үү гэсэн хүсэлтийг
О.Алтангэрэл даргад
тавьсан юм. Хүсэлтийг
маань хүлээн авч
улмаар төсөл болгон
хэрэгжүүлж, 30 мянган
бортгийг үнэ төлбөргүй
өгснөөс гадна заг
тарих бортгонд хөрсөө
бэлтгэх ажлыг нутгийн



Ц.ДАШЦЭРЭН

Зүүнбаян-Улаан сумын
иргэн, МУГЖ

Ер нь ажиглаад байхад
О.Алтангэрэл ядарсанд
тусалж, боловсролыг
дэмжихэд их зүйл
хийдэг, нутгаа гэсэн
сэтгэлтэй. Өвөрхангай
аймгийн АН-ыг
хэдэн жил удирдаж
байгаагаас хараад
ажлын арга барил
их зөв, эргэх холбоо
сайтай, нуруутай улс
төрч гэж боддог юм.
Одоо залуусын эрин
үе эхэлж байна. Нутгаа
гэсэн ийм сэтгэлтэй,
боловсролтой залуусаа
л тулмаар байгаа юм.



Т.БАЯНМӨНХ

Баянгол сумын багийн Засаг
дарга

О.Алтангэрэл дарга бол
УИХ-ын гишүүн биш



А.ЧУЛУУНМӨНХ

Төгрөг сумын иргэн

Эгч нь сумандаа
цэцэрлэгийн
эрхлэгчээр 14 жил,
сумын Ардчилсан
намын даргаар 8
жил ажилласан.
Алтангэрэлийг
Өвөрхангайн АН-н дарга
бороход нь овоо дориун
хуульч хүүхэд болж дээ
гэж баярлаж байлаа.
Сая ажлаа өгч байгаа

**Н.БАЯРСАЙХАН**

Арвайхээр сумын иргэн,
мэс заслын их эмч

Би ардчиллыг анхнаас
дэмжиж ирсэн хүн.
Ардчилал бидэнд их
зүйлийг авчирсан.
О.Алтангэрэл бол АН
дотроо ирээдүйтэй
улс төрч. Дээр нь
Өвөрхангайнх. Нутаг
оронтойгоо ч байнга
холбоотой байдаг юм
билээ.

**Д.ЧАНЦАЛ**

Сант сумын багийн Засаг
дарга

Ер нь муンドаг хүн
шүү дээ. Иргэд, аж
ахуйн нэгж, төрийн
байгууллагатай байнга
холбоотой байж, тусалж
дэмждэг болохоор
манай суманд нэр хүнд
сайтай. Сүүлд гэхэд
сургуульд түүхийн
тэнхим тохижуулж өгч,
багуудын дунд өдөрлөг
зохион байгуулсан.

**Г.ГАНБАЯР**

Баян-Өндөр сумын ЕБС-ийн
багш

Манай сумын сургуульд
Түүхийн кабинет
тохижуулж өгснөөс нь
хойш л О.Алтангэрэл
хуульчийг мэдэх
болсон. Багш нар бид
анх удаа ийм тэнхимтэй
болсондоо баяртай
байгаа. Сурагчдын
аятай таатай сурх
орчинг бүрдүүлж өгсөн,
цаг үеэ олсон хөрөнгө
оруулалт хийсэнд
баярласнаа илэрхийлье.



сумдад ард иргэдийг
нэгтгэсэн "Дэлгэр
зун", "Налгар намар"
зохион байгууллаа.

Залуу уяачдад чиглэсэн
сургалтыг бас бүх
сумдаар хийллээ.
Залууст ирээдүйнх
нь гарц гаргалгааг
нь хэлж өгсөн олон
төрлийн арга хэмжээ
зохион байгуулдаг
гээд агуулгаараа том
ажлууд хийдэг хүн. Сайн
хуульчийнхаа хувьд улс
төрд байх ёстой хүн гэж
боддог.

**Ц.МЯГМАРСҮРЭН**

Есөнзүйл сумын багийн
Засаг дарга

Хувь хүн, хуульч
хүнийх нь хувьд би
О.Алтангэрэл даргыг
хүндэтгэдэг. Олонд
хүртээмжтэй ажлыг
чимээгүй хийгээд
л явдаг, поопроод,
зарлаад байдаггүй
нь таалагддаг. Бүх

19



Эвт айлын хаяа

*Дархан хилийн
дээсэн дээр*

*Энх тайваны
харуул*

*Дайчин эрсийн
тангараг дээр*

*Эрдэнэ зуугийн
хэрэмний*

*Зуун найман
суварга дээр*

*Энэ зууны
өргөөний*

*Зуун түмэн
ценхон дээр*

*Тусгаар тогтнол
чамайг*

*Тунхаглан
бичнэ би!*

*Ардын уран
зохиолч*

Д.Пүрэвдорж

БИД ӨВӨРХАНГАЙЧУУД

















ТӨРӨӨС ОЛГОХ УРАМШУУЛЛААС ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭ СУУТГАН ТӨЛҮҮЛЭЭРЭЙ



ХУУЛИЙГ
БОЛОВСРУУЛСАН:
Хуульч **O.Алтангэрэл**



ХУУЛИЙГ САНААЧЛАН
БАТЛУУЛСАН:
УИХ-ЫН ГИШҮҮН **Ц.Туваан**

Иргэн шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах хүсэлтээ хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар гаргасан байх

ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулж, харьяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-тай гэрээ байгуулсан байх

Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч

Төрөөс олгох ноосны, сүүний, арьс, ширний, улаан буудайн, хүнсний ногооны урамшуулал авах эрх үүсэн иргэн

Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий иргэн

ТА

Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэн

Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал авах иргэн

САНАМЖ: Та

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй байх;
- Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй байх;
- Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхийг зөвшөөрч, хүсэлт гаргасан байх хэрэгтэй.